

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (Н.Цэрэнбат)-д даалгасугай.
3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улс болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (Н.Цэрэнбат) болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ Н.ЦЭРЭНБАТ